# Шинжээчийн тайлан

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: | Шинжлэх Ухаан Технологийн их сургууль,<br>Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн сургууль |
| Хөтөлбөрийн нэр: | Нийгмийн ажил |
| Индекс: | D093201 |

Шинжээчийн баг:

| | |
|---|---|
| Ахлагч: | Т.Цэндсүрэн |
| Гишүүд: | Б.Сүх-Очир<br>Г.Мөнхнасан |

2020 оны 5 сарын 12-13

**Агуулга**

**Товчилсон үгийн тайлбар ........ 4**

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт ........ 5**

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга ........ 6**

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт ........ 6**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт ........ 6

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа ........ 9

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл ........ 11

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт ........ 14

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа ........ 18

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа ........ 22

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт ........ 25

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс ........ 30

II. Оюутнуудын нэрс ........ 31

III. Ажил олгогчдын нэрс........ 32

IV. Төгсөгчдийн нэрс ........ 33

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал ........ 34**

**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| БСШУСЯ | Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам |
| БМИҮЗ | Боолвсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл |
| БуХС | Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль |
| БУСТА | Бизнесийн удирдлагын сургалтын төлөвлөгөөний алгоритм |
| БСС | Боловсрол судлалын сургууль |
| ГБХЗХГ | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар |
| МУБИС | Монгол улсын боловсролын их сургууль |
| МУТИС | Монгол улсын технологийн их сургууль |
| ОУ | Олон улс |
| ИС | Их сургууль |
| ЗГХА | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг |
| ШУТИС | Шинжлэх ухаан технологийн их сургууль |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ОУБ | Олон улсын байгууллага |

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<table>
<tr><td>Сургуулийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль</td></tr>
<tr><td>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</td><td colspan="2">Нийгмийн ажил<br>Social Work</td></tr>
<tr><td>Индекс</td><td colspan="2">D092301</td></tr>
<tr><td>Шинжээчид</td><td colspan="2">1. Т.Цэндсүрэн - МУБИС-ийн БСС-ийн Нийгмийн ажил арга зүйн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор, шинжээчийн багийн ахлагч<br>2. Б.Сүх-Очир - Олон улсын Улаанбаатарын их сургуулийн тэнхимийн эрхлэгч, доктор, шинжээчийн багийн гишүүн<br>3. Г. Мөнхнасан - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийслэлийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга, шинжээч</td></tr>
<tr><td>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</td><td colspan="2">Б.Мядагмаа -БМИҮЗ-ийн ахлах мэргэжилтэн</td></tr>
<tr><td rowspan="8">Төлөвлөгөө</td><td>Он сар өдөр</td><td>Хийгдсэн байх ажлууд</td></tr>
<tr><td>2020.5.27</td><td>Нийгмийн ажил хөтөлбөрийн товч танилцуулгатай танилцах</td></tr>
<tr><td>2020.5.27</td><td>Сургуультай танилцах</td></tr>
<tr><td>2020.5.27</td><td>Суралцагч оюутнуудтай хийх уулзалт</td></tr>
<tr><td>2020.5.28</td><td>Төгсөгч нартай хийх уулзалт</td></tr>
<tr><td>2020.5.28</td><td>Ажил олгогч нартай хийх уулзалт</td></tr>
<tr><td>2020.5.27</td><td>Багш нартай хийх уулзалт</td></tr>
<tr><td>2020.5.27-28</td><td>Өөрийн үнэлгээний тайлантай холбоотой илрэл, нотолгоотой танилцах, тодруулга лавлагаа авах</td></tr>
<tr><td>Шалгуур шаардлага /журам/</td><td colspan="2">БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06-р сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ын дагуу ажиллав.</td></tr>
</table>

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

БСШУЯ-ны Шинжлэх Ухаан, Технологи, Дээд Боловсролын Бодлого зохицуулалтын газраас ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны Сургуульд олгосон “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл” /№960009/-ийн хавсралтын жагсаалтанд зааснаар 1996 оны 03 сарын 09-ны өдрийн 84 тоот тушаалыг үндэслэн Нийгмийн ажил мэргэжлээр элсэлт авч, сургалтын үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Тус хөтөлбөр нь 1997-2000 онд МУТИС-ийн Инженерийн суурь боловсролын сургуулийн Нийгмийн ухааны тэнхимд 2000-2001 онд МУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн халамж зүйч-Философийн тэнхимд, 2002-2008 онд ШУТИС-ийн Хүмүүнлэгийн Ухааны сургуулийн Нийгмийн ажил-психоанализын профессорын багт, 2008-2014 онд ШУТИС-ийн Нийгмийн Техологийн Сургуулийн Нийгмийн ажлын профессорын багт, 2014 оноос одоог хүртэл ШУТИС-ийн БуХС-ийн Нийгмийн ухаан салбарт харъяалагдаж байна. Мэргэжилтэн бэлтгэж ирсэн 22 жилийн хугацаанд “Нийгмийн ажил” хөтөлбөрөөр 710 бакалавр төсссөн ба одоо 116 оюутан суралцаж байна.

Нийгмийн ажил хөтөлбөрөөр бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь БСШУЯ-ны БМИҮЗ-ийн 2014 оны 09 сарын 09-ний өдрийн 01 тогтоолоор 5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлүүлсэн байна.

“ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал 2012-2021” болон “ШУТИС-2021 он” мастер төлөвлөгөөний хэрэгжилт, “Нийгмийн ажил” хөтөлбөрийн агуулга, арга технологи, удирдлага зохион байгуулалт, үр дүнгийн өнөөгийн байдалд өөрийн үнэлгээ өгч цаашдын зорилго чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**
Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

- Нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ (PEST анализ)
- Гадаад дотоодын их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын жишиг, ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулан боловсруулсан.
- Нийгмийн ажил хөтөлбөрийн мэргэжлийн хичээлүүдийн нэршил, багц гадны их дээд сургуулиудын хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгатай нийцсэн байна.

**Анхаарах асуудал:**

- Нийгмийн ажил, нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн чиг хандлага болон эрх зүйн шинэчлэлийг судлан, хөтөлбөртэй уялдуулж төгсөгчийн ажлын байрны эрэлт хэрэгцээг тодорхойлоход ач холбогдол өгөөгүй байна.
- Сургалтанд оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээг ямар аргаар хийж, оролцогч талуудыг хэрхэн хамруулсан талаар илрэл нотолгоо дутуу байгааг анхаарах

**Зөвлөмж:**

- Хөтөлбөр нь сургалтанд оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн байдалд дүн шинжилгээ хийж, тэдний санал санаачлагыг тусгадаг байх.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад, дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулалт хийхдээ ямар шалгуурыг баримтлах, давуу болон сул талаа тодорхойлж хийх

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- CDIO Syllabus 2.0-ийн 1-р түвшний сургалтын үр дүнгүүд
- Хөтөлбөрийн сургалтын зорилгууд

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн онцлогт тохируулан зорилго, үзэл баримтлалыг боловсруулсан.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь CDIO сургалтын аргын 1-р түвшний үр дүнтэй уялдуулсан.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар ажил олгогч, төгсөгч нарт танилцуулдаг энэ талаар тэдний саналыг сонсдог байхад анхаарах.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилгод судалгаа хийх, ажил олгогч төгсөгч нараас санал авах, хэлэлцүүлэх

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Батлагдсан хөтөлбөр
- ШУТИС-ийн Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэл
- 2014, 2016 онд батлагдсан сургалтын төлөвлөгөө
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт (CDIO аргын 2-р түвшин)

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2014 оноос хойш БМИҮЗ-өөр Нийгмийн ажил хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлснээс хойш сургалтын төлөвлөгөөг 2 удаа шинэчлсэн байна.
- Сургалтын төлөвлөгөөг шинэчлэн батлахдаа Нийгмийн ажлын хөтөлбөрийн мэргэжлийн багш нарын баг, Нийгмийн ухааны салбарын хурал, БуХС-ийн хөтөлбөрийн дэд хороо, ШУТИС-ийн Хөтөлбөрийн ерөнхий хороогоор тус тус хэлэлцүүлдэг байна.

**Анхаарах асуудал:**

- БСШУЯ-ны сайдын А/174 тушаалаар мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр нь 12 бүрэлдэхүүн хэсэгтэй байх атал тухайн хөтөлбөрийн хувьд 10 бүрэлдэхүүн хэсэгтэй Төгсөгчийн эзэмших ур чадвар, Суралцагчийн үнэлгээ, Удирдлага мэдээллийн сангийн талаар мэдээлэл орхигдсон байгааг анхаарч хөтөлбөрт зайлшгүй нэмж тусгах
- Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлд (БСШУСЯ, 2020 оны 3 сарын 2) Нийгмийн ажил хөтөлбөр 120 багц цаг сургалт явуулах зөвшөөрөлтэй байгаа боловч одоо мөрдөж байгаа (2016 онд батлагдсан) сургалтын төлөвлөгөө нь 122 багц цагийн агуулгатай буюу тусгай зөвшөөрлийг зөрчсөн дутагдал ажиглагдаж байгааг анхаарч засах шаардлагатай.
- Мэргэжлийн суурь хичээлийн эзлэх хувийг багасгаж, мэргэшүүлэх хичээлийг нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллах.
- Хөтөлбөрт дотоод болон гадаад чанарын батгаажуулалт хэрхэн хийгдэж байгаа нь тодорхойгүй (ШУТИС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам 2019 оны 6 сарын 1-нээс мөрдөж байгаа)

**Зөвлөмж:**

- Салбарын зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих механизмийг сайжруулахад анхаарах
- Хичээлийн хөтөлбөрийг баталгаажуулахдаа сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглүүлж, агуулга, эзэмших чадварын хувьд харилцан залгамж холбоог ханган, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт хэлбэрийг тусгах
- Нийгмийн ажил хөтөлбөрийн төгсөгчийн эзэмших цогц чадамж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүнгийн хамаарлыг тооцож ажиллах шаардлагатай.

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**
Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- 2014, 2016 оны сургалтын төлөвлөгөөний харьцуулсан хүснэгт
- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, дадлагын тайлан
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага**

- Үр дүнд суурилсан боловсрол болон CDIO сургалтын аргууд болон БУСТА загварыг гарган мөрдөж ажилладаг.
- Зайн болон цахим хичээлүүдийг Е-контент түвшинд боловсруулан сургалтад ашиглаж байна.
- Нийгмийн үйлчилгээний төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээтэй, Солонгос болон бусад орнуудын их сургууль, коллежтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллаж байна.

**Анхаарах асуудал:**

- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын хамаарлын уялдаа холбоог тодорхой, нарийвчлан гаргаж, дүн шинжилгээ хийх.
- Нийгмийн ажлын дээд боловсролын стандарт болон хөтөлбөрийн онцлогтой уялдуулан дадлагын багц цагийг (дадлага нийтдэ 6 кр байна) нэмэгдүүлэхэд анхаарах. (Танилцах дадлага-2кр, Хувь хүн гэр бүлтэй ажиллах дадлага-2кр, Байгууллага олон нийттэй ажиллах дадлага-2 кр)
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын хоорондын хамаарлыг (Хүснэгт 16) гаргахдаа нарийвчлалыг анхаарах хэрэгтэй байна. Нийгмийн ажлын үндэс, Хүүхэд хамгаалал, Ерөнхий социологи, Нийгмийн сэтгэл судлал зэрэг зарим хичээлүүд нь хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварыг (7-оос дээш) бүрэн хангаж байгаа эсэхийг дахин нягталж харах

**Зөвлөмж:**

- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн үр дүнтэй нийцсэн байдалд дүн шинжилгээ хийх

- Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнүүдийн онол, практикийн зохистой харьцааг сайжруулах үүднээс суралцагчдаас авсан судалгааны мөрөөр мэргэжлийн багш нар, хөтөлбөрийн дэд хороо анхаарч ажиллах шаардлагатай. Тухайлбал сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлээр оюутны мэргэжил эзэмших, хөгжих хэрэгцээтэй нийцэж байгаа байдлыг харвал 36.6 хувь нь бүрэн нийцдэг, 58.1 хувь нь зарим талаараа нийцдэг, онол болон практик хичээлээр өгч буй мэдлэг, чадвар, дадал нь судалгаанд оролцогч оюутны 28.3 хувийн үнэлгээгээр тэдний сурч боловсрох хэрэгцээтэй бүрэн нийцэж байна гэсэн байна.
- Батлагдсан сургалтын төлөвлөгөөний оюутанд санал болгох хувилбараар Оюутны цагийн ачаалалд дүн шинжилгээ хийж, тооцох шаардлагатай.
- Нийгмийн ажлын дадлага хийсэн оюутнууд болон байгууллагын тоо, дадлага удирдагч, түүнд ногдох цагт дүн шинжилгээ хийж ажиллах

**2.2 Сургалтын арга зүй**
Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- CDIO сургалтын арга зүйг хэрэгжүүлэх зөвлөмж
- Сургалтын арга зүйд хийсэн анализ (Өөрийн үнэлгээний тайлан, Зураг 6,7)

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын арга зүй нь багшийн сургах арга, оюутны сурах үйл ажиллагаанаас бүрдэх бөгөөд оюутан төвтэй, тэдний оролцоог дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.
- Хөтөлбөрийн суурь ойлголтыг нэгтгэж интеграц хийх, өөр хоорондоо холбоо хамааралтай мэдлэг, ур чадварыг нэгтгэх зорилгоор шинэ хичээл бий болгож, хөтөлбөрт оруулах боломжтой

**Анхаарах асуудал:**

- Нийгмийн ажил хөтөлбөрийг боловсруулахад CDIO Нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах аргачиллыг мөрдсөн байгаа ба харин БУСТА загварыг хэрхэн мөрдөж байгаа нь тодорхойгүй байна.
- Хичээлийн кредит болон хэлбэрт дүн шинжилгээ хийх
- Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд хэрхэн зөвлөн тусалдаг, суралцах үйл ажиллагааг хэрхэн дэмжих талаар анхаарах, энэ талаар сургалтын баримт бичгүүдэд оруулах шаардлагатай байна.
- Хичээлийн хөтөлбөр (стандартаас тусад нь) боловсруулах удирдамж, заавар боловсруулж хэрэгжүүлэх

**Зөвлөмж:**

- CDIO, БУСТА загвар нь хөтөлбөрийн онцлогтой (нийгэм, хүмүүнлэгийн) нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох хэрэгтэй байна.
- Хичээлийн танилцуулга нь мэдлэг, чадварын ерөнхий хүрээгээр тодорхойлогдож байгаа эсэхийг нотлох
- Хичээлд хэрэглэгдэж буй арга зүй, хэлбэр, зохион байгуулалтыг тодорхой төлөвлөх. Тухайлбал лекцийн хичээлийн арга зүй, семинарын хичээлийн арга зүй,

бие даалтын хэлбэр, арга зүй, шалгалтын хэлбэр арга зүй болон зохион байгуулалтын хэлбэрүүдийг хичээлийн стандартад тодорхой тусгах мэргэжлийн багш нар, хөтөлбөрийн дэд хороо энэ талаар төлөвлөж ажиллах хэрэгтэй.

**2.3 Суралцагчийн үнэлгээ**
Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтанд ашиглаж буй үнэлгээний арга зүй
- ШУТИС-ийн Оюутны мэдлэгийг үнэлэх нэгдсэн систем
- ШУТИС-ийн оюутнуудын кредитийн урамшуулал олгох журам
- Ректорын нэрэмжит тэтгэлэгт хамруулах журам

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн 70, улирлын эцсийн шалгалтын 30 оноогоор үнэлж байна. Улирал бүр хичээл бүрээр сургалтын үнэлгээнд дүн шинжилгээ хийдэг.
- Суралцагчийн амжилтыг үнэлгээний голч дүнгээр үнэлж байна.
- UNIMIS системд оюутны дүнг баталгаажуулан оруулдаг

**Анхаарах асуудал:**

- Оюутныг тасралтгүй хөгжүүлэх идэвхтэй бүтээлч аргыг хэрэглэн ур чадварыг хөгжүүлэхэд багш нар анхаарах.
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх мөн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд анализ хийдэг байх
- Суралцагчийг тасралтгүй хөгжихөд тусалж байгаа эсэхэд үнэлгээ шинжилгээ хийдэг, сайжруулах алхамууд тодорхой төлөвлөлттэй гүйцэтгэгддэг байхад анхаарах

**Зөвлөмж:**

- Суралцагчийн сурлагын ахиц амжилтанд дүн шинжилгээ хийж, сурлагын ахицын талаарх статистик мэдээллийн мөрөөр тогтмол ажиллах,
- Хөтөлбөрийн хичээлийн үнэлгээний сан бүрдүүлэн ажиллах, үнэлгээний сангийн агуулга хэлбэрийг зохих түвшинд үнэлдэг байх
- Нийгмийн ажил хөтөлбөрт суралцагчийн үнэлгээний талаар бүлгийг нэмж оруулах

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

**3.1 Сургалтын орчин**
Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад

нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**
Хичээлийн байраар явж танилцахад хүрэлцээ сайтай, оюутан болон багш нар бие даан хөгжих боломж нээлттэй гэж үзлээ. Тухайлбал,

- Олон нийтийн арга хэмжээ явуулах 120 хүний суудалтай мини театр нь мэргэжлийн Нийгмийн ажлын оюутнуудад өөрийгөө илэрхийлэх олон нийтийн арга хэмжээнд оролцох дадлага суулгахад давуу талтай байна. 100, 150 хүний суудалтай 2 иж бүрэн тоногдлогдсон лекцийн танхимтай байна.
- Сүүлийн 3 жилийн хугацаанд сургалтын тоног төхөөрөмжинд 263,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн сайжруулсан байна.
- Сүүлийн 5 жилд байрны тохижилт, урсгал засварт 804,4 сая төгрөг зарцуулсан байна.
- Сүүлийн хийгдсэн 835 оюутны сэтгэл ханамжийн судалгааны дүнг харахад сургалтын тоног төхөөрөмж, дундаас дээш үзүүлэлтэй мөн гэрэлтүүлэг, анги танхим, цахим хэрэглээ бүрэн хангалттай гэж гарсан байна.
- 400 Оюуны дотуур байртай байгаа нь бүх оюутнуудад бүрэн хүрэлцээтэй байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд 140,1 сая төгрөгний урсгал засвар хийгдсэн бөгөөд энэ онд дээврийн иж бүрэн засвар хийгдэхээр төлөвлөгдсөн байна.
- 2017 онд “Багш хөгжлийн төв”-ийг шинээр байгуулсан бөгөөд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж болон амрах, уулзалтын өрөө зэргийг тохижуулсан байна.
- Багшийн хөгжлийг дэмжих санд сургуулийн нийт орлогын 1-3 хүртэл хувийг зарцуулах журамтай бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 62,4 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Хичээлийн байрны 1 давхрын 00-д хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан өрөөг тохижуулсан ба гадаа шатыг стандартын дагуу налуу замтай болгосон байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2017 онд Багш ажилчдын хүүхдэд зориулсан 80 хүүхдийн багтаамж “Эрдэм цэцэрлэг”-ийг өөрийн байрыг түшиглэн сургуулиас 91 сая, багш ажилчдын хандив 10 сая нийт 101 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж байгуулсан байгаа нь сайшаалтай байна.

**Анхаарах асуудал:**

- Бүх давхрын 00-ыг ХБИ-д зориулсан өрөөг тохижуулах шаардлагатай гэж зөвлөж байна.

**Зөвлөмж:**

- Оюутны дотуур байранд амьдарч байгаа оюутнуудад амьдрах ухааны сургалт хийх, дотор засварт анхаарах.

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**
Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Тус хөтөлбөрт нийт 11 багш байгаагийн 81,1 хувь докторын зэрэгтэй байна. Сургалтын 2 мастертайгаар ажиллаж байна.
- Хичээлийн жилийн эхэнд салбар бүр тухайн жилд сургалт явуулахад шаардлагатай материал, сургалтын жагсаалтыг сургуулийн захирлаар батлуулдаг байна.
- Хичээлийн улирлын эхэнд хичээл бүрээр төлөвлөгөө гаргаж салбарын эрхлэгчээр батлуулдаг байна.
- ШУТИС-ийн Электрон сургалтын хөтөлбөрийг баталсан ба Cloud UNIMIS, UNILMS, E-Lib.MS системүүдийг ашигладаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Цахим хичээлийг боловсруулж, сургалт явуулж эхэлсэн байна.
- Эрдмийн зэрэг цолтой багшийн тоо хангалттай гэж үзлээ. 2014 онд хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлснээс хойш эрдмийн зэрэг цолтой багш нарын тоо өссөн үзүүлэлттэй байна.

**Анхаарах асуудал:**

- Онлайн хичээлийн тоног төхөөрөмжийг сайжруулах.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэрэглэгдэхүүний хэрэгцээний судалгааг хийх, түүнийг хангаж буй байдалд дүн шинжилгээ хийж ажиллах

**Зөвлөмж:**

- Багш нарын тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тухай бүр хийх.

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- 90 хүний суудалтай номын сантай ба гэрээр олгодог нь уян хатан зохицуулалтай байна. 1-р курсийн оюутнуудад зориулан, мэргэжлийн ном сурах бичгээр үзэсгэлэн зохион байгуулдаг нь сайшаалтай.
- Жил бүр БуХС-ийн номын санд шинээр ирсэн ном, сурах бичгээр өдөр тутмын үзэсгэлэн зохион байгуулж, ном зүйн лавлагаа өгдөг байна.
- Дижитал номын сантай.
- Нийгмийн ажил хөтөлбөрийн оюутнууд болон бусад их дээд сургуулийн нийгмийн ажлын чиглэлээр суралцаж буй оюутнууд сууж ашиглах бүрэн боломжтой номын сантай нь давуу талтай байна.
- Сүүлийн 4 жилд сургуулийн номын фондыг 95,415 сая төгрөгөөр баяжуулсан бол 38,45 сая төгрөгний гадаад, дотоод хэвлэл захиалсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөрөнгө оруулалт маш сайн хийгдсэн.
- Төрөлжсөн номын сантай.

**Анхаарах асуудал:**

- Бусад оюутан судлаачдад номын сангийн байршил мэдээллийг сайн өгөх.
- Мэргэжлийн номын санд (Каритас-Чех) номын фондын судалгаа хийж, түүнийг баяжуулахад анхаарах

**Зөвлөмж:**

- Номын баяжилтанд анхаарч хүрэлцээтэй байлгах.
- Хөтөлбөрийг ном сурах бичгээр хангах тэнхимийн төлөвлөлт хийж, хэрэгжүүлэлтийг анхаарч ажиллах

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**
Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ШУТИС-ийн захирлын тушаалаар 2017 оны 10 сарын 09 ны өдрийн А/182 тоот тушаалаар ШУТИС-ийн хөтөлбөрийн хороо шинэчлэн байгууллагдсан. БуХС-ийн хөтөлбөрийн дэд хороо удирдлага болон салбар тус бүрээс төлөөллийг хамруулсан 7 гишүүнтэй, хөтөлбөрийн дэд хорооны ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.
- Нийгмийн ажлын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх дүрэм журмуудыг ШУТИС-ийн удирдах зөвлөлөөр баталдаг.
- Шилжилт хөдөлгөөн, санхүү, төлбөр болон бусад үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол, өргөдлийг БуХС-ийн захирал санхүүгийн албаар дамжуулан шийдвэрлэдэг.
- Хичээлийн жилийн эхэнд “Салбар болон хөтөлбөрийг сайжруулах төлөвлөгөө”-г боловсруулж, бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулан, төгсгөлд хамт олноороо хэлэлцүүлж, ажлын үр дүн биелэлтийг дүгнүүлдэг.
- Сургалтын удирдлага, мэдээллийн тогтолцоо нь UNIMIS системийг хэрэглэж сургалтын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, сургалтанд багшлах, үйлчлэх боловсон хүчин, оюутны бүртгэл, сургалтын хөтөлбөр, хичээлийн стандарт, агуулга, сургалтын үр дүнгийн мэдээллийн сан бүхий сургалтын

дэвшилтэт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үнэлгээ хийх зэрэг цогц программ хангамжтай.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хөтөлбөрийн дэд хороогоор 2019 оны 4 сарын 12-нд хэлэлцүүлсэн.
- UNIMIS системийг 4 удаа сайжруулан баяжуулсан.

**Анхаарах асуудал:**

- Нийгмийн ажил хөтөлбөрийн төлөвлөгөө, тайланг гаргаж, түүнд дүн шинжилгээ хийж ажилладаг байх
- Оюутны санал асуулгын мэдээ, түүнийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах талаар анхаарч ажиллах
- Хэдэн санал гомдол авсан, хэрхэн шийдсэн, ямар санал гомдлууд гол төлөв ирж байгаад дүн шинжилгээ хийж ажиллах

**Зөвлөмж:**

- Нийгмийн ажил хөтөлбөрийн төлөвлөгөө, тайланг салбарын тайлангаас тусад нь жил бүрээр гаргаж, дүн шинжилгээ хийдэг болох
- Аливаа бичиг баримтыг хөтөлбөрийн хувьд тусгайлан авч үздэг, хадгалдаг байх
- Удирдлага мэдээллийн системийг ашигласнаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ямар өөрчлөлт гарсан талаар дүн шинжилгээ хийж ажиллах
- Хичээлийн үнэлгээний удирдамж, шалгуур үзүүлэлт хэрхэн хийж албан тушаалын зэрэглэл, ажлын үр дүнтэй уялдуулж ажиллахад анхаарах

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**
Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Тайлант хугацаанд нийгмийн ажлын хөтөлбөрийн багш, судлаачид дотоод, гадаадын хамтарсан нийт 105,4 сая төгрөгийн өртөгтэй 14 төсөлд оролцсон байна.
- Оюутан солилцооны хөтөлбөрийг ОХУ, БНСУ, Япон зэрэг орнуудын их сургуультай хамтран хэрэгжүүлдэг. Энэ нь дадлагын хичээлээр дамжин хэрэгждэг байна.
- Багш нар гадаад, дотоодын 11 байгууллагын 15 тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.
- Хамтын ажиллагааны хувьд Эрдэм шинжилгээний хурал, багш оюутан солилцоо, дадлагын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зорион байгуулах зэрэг хэлбэртэй байна.
- Төгсөгчдийн дунд 567 гишүүнтэй цахим групп ажиллуулж, мэдээллээ солилцдог.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутан солилцооны хөтөлбөрийг сайн хэрэгжүүлдэг.
- Гэрээ, санамж бичиг хангалттай хийгддэг.

**Анхаарах асуудал:**

- Хамтын ажиллагаа болон нийгэмд үзүүлсэн үйлчилгээг баримтжуулж, түүнд дүн шинжилгээ хийхэд анхаарах
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны төлөвлөлт болон тайланг бүрдүүлж ажиллах
- Бусад нийгмийн үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллаж буй ажлын үр нөлөөг тооцож ажиллах

**Зөвлөмж:**

- Өөрийн үнэлгээний дүгнэлтүүдийг батлах, илрэл нотолгоог бүрдүүлж ажиллах.
- Хамтын ажиллагаа болон нийгэмд үзүүлсэн үйлчилгээний тайланд дүн шинжилгээ хийх
- Сургалт, эрдэм шинжилгээний төвүүдийн үйл ажиллагааны чиглэл, хэрэгжилтэнд анхаарч ажиллах

**4.3 Санхүүжилт**
Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- БуХС-ийн 2014-2018 оны санхүүгийн үзүүлэлт харьцангуй тогтвортой байна.
- БуХС-ийн нэг оюутанд ноогдох зардал 2015 оноос байнга өссөн үзүүлэлттэй байна.
- “Нийгмийн ажил” хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутнууд, багшийн хөгжил, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих үйл ажиллагаанд ШУТИС-ийн БуХС-ийн сургалтын нийт орлогоос зарцуулдаг.
- Хөтөлбөрийн багш нар хөтөлбөрийн чанар, үр өгөөж, ач холбогдлыг дээшлүүлэх, түүнийг олон улсын жишигт хүргэх, ижил төстэй сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоож, сайн туршлагыг нутагшуулан, өөрийн давуу тал, онцлогийг сурталчилах зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн багш нар нийгэм, эдийн засгийн шинж чанартай томоохон судалгаанд оролцдог.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн санхүүгийн үйл ажиллагаанд анализ хийх
- Хөтөлбөрөөр суралцагчид болон багш нарын хөгжилд хөтөлбөрийн орлогоос зарцуулах зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж түүний мөрөөр ажиллах

**Зөвлөмж:**

- Гадаадын улс орны сургуулиудын тэргүүн туршлагыг хөтөлбөрийн санхүүжилт бүрдүүлэхэд дутмаг ашиглсан, төгсөгчдийн оролцоо, бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх нэг шалгуур үзүүлэлтэд санхүүгийн асуудлыг оруулж өгөх
- Сургууль болон бусад эх үүсвэр /төсөл, сургалт, хандив/-ээс хөтөлбөрийн санхүүжилтийг тодорхой болгох

**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**
Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- БуХС-ийн вэб хуудас (www.sbh.edu.mn)-т Нийгмийн ажил хөтөлбөрийн элсэлтийн журам, босго оноог байршуулдаг.
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдийн мөшгих судалгааг төлөвлөгөөний дагуу хийж, ажил эрхлэлтийн байдлыг тогтоодог.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Олон нийтийн дунд сургуулийн нэр хүнд сайн тул элсэгчдэд эерэгээр нөлөөдөг.
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр төгсөлт хийсэн тоо, төгсөгчдийн ажил эрхлэлт зэрэг сайнаар нөлөө үзүүлдэг.

**Анхаарах асуудал:**

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр Нийгмийн ажил хөтөлбөрийн талаар мэдээлж, идэвхжүүлэлтийн тохирсон арга, хэлбэрийг ашигладаг гэсэн боловч баримт байхгүй.
- Судалгааны тайланг хэрхэн яаж ашигладаг талаарх баримт

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн давуу болон сул талаа илэрхийлэх баримт илрэл нотолгоонд дүн шинжилгээ хийх

**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**
Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Нийгмийн ажил хөтөлбөрийн эрдэмтэн, багш нар өөрсдийн явуулж буй сургалт, эрдэм шинжилгээ, инноваци, мэргэжил, хөтөлбөр сурталчилах үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, төгсөгчдөдөө мэдээллийн бүхий л сувгийг ашиглан ил тод дэлгэрэнгүй мэдээлэл түгээдэг.
- Хөтөлбөрийн багш, оюутан, төгсөгчдийн “Нийгмийн ажлын нэгдсэн групп” бүлгийг ашиглан хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, сайн туршлага, хөтөлбөрөө сурталчилах зэрэг мэдээллийг ил тод, тогтмол түгээдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаад нэр хүнд сайн
- Эрдэмтэн багш нарын нарын авлага, эрдэм шинжилгээний ажил, цахим мэдээлэл олон нийтэд үнэн зөв, ил тод хүрдэг.

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог хангаж бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

**5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**
Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- ЭЕШ-нд 480-аас дээш оноо авсан элсэгчид орох боломжтой байна.
- Сурагчдын аяллын хөтөлбөрөөр таниулан сурталчилж элсэгчдийг татдаг байна.
- “Багш, оюутан” хөтөлбөр зохион байгуулдаг.
- Гадаад оюутан суралцсан тохиолдол байхгүй боловч дадлага болон оюутан солилцоогоор БНСУ-д хийж байгаа ба ХБНГУ, Япон, Австрали улсад дадлага хийхээр гэрээ байгуулсан байна. Ковид-19 вирусын дэгдэлтээс хамаарч хугацаа хойшилсон.
- Бидний бахархал уулзалт хийж байгаа нь сайшаалтай байна.
- Тухайн хөтөлбөрөөр элсэгчдэд зориулсан мэргэжил сурталчлах үе шат бүхий үйл ажиллагаа явуулдаг.
- Дотоодын болон гадаадын байгууллагууд, их сургуулиудтай хамтран ажиллах боломж ихтэй.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Бидний бахархал уулзалтыг жил бүр зохион байгуулж хэвшсэн.
- “Багш, оюутан” хөтөлбөр зохион байгуулдаг байна

**Анхаарах асуудал:**

- ЕБС төгсөгчдийн тоо буурч байгаа тул энэхүү эрсдэлийг бууруулахын тулд мэдээлэл, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөтэй, үр дүнтэй, зохион байгуулалттайгаар хийх
- Гадаадаас оюутан элсүүлэх тал дээр анхаарах

**Зөвлөмж:**

- Дотоодын болон гадаадын байгууллагууд, их сургуулиудтай хамтран ажиллах.
- Сургуулийн нэр хүнд, хөтөлбөрийн олон жилийн туршлагад үндэслэн жил бүрийн элсэлтээ нэмэгдүүлэх боломжтой
- Гадаадын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулиудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх, гадаад оюутан элсүүлэн авах талаар ажиллах

**5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**
Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээл сонголтоор хичээлийн хуваарийг өөрсдөө зохиох нь өөрийгөө хөгжүүлэх боломжийг нь нээж өгч байна.
- Шинээр элсэгч оюутнуудад зориулсан зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээг төлөвлөсөн байдаг ба зөвлөх багш томилдог.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Холбогдох дүрэм, журмыг цахимаар багш оюутнуудад хүргэдэг

**Анхаарах асуудал:**

- Сургалтын албаны ачаалал их байдгаас оюутан бүрт хүрч үйлчлэх боломж бүрдэхгүй байгааг анхаарах
- Оюутнуудын дунд мэргэжлийн болон сонирхлын бүлэг, клуб байгуулан ажиллах, одоо ажиллаж буй клубын үйл ажиллагааг оюутнуудад сурталчилж, танилцуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх.

**Зөвлөмж:**

- Оюутны хөгжил үйлчилгээний албаны нэг салбарыг БуХС-ын Оюутны зөвлөлийн дэргэд байгуулж, оюутны клубууд удирдагч багш нарын тусламжтайгаар бүхий л талаас зөвлөх дэмжих үйлчилгээг хөгжүүлэх боломжтой.

**5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**
Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургуулийн зүгээс суралцагчдын нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа зохион байгуулахад тогтмол дэмжлэг үзүүлдэг.
- Оюутныг сайн дурын ажил болон сурлагаар амжилт үзүүлэхэд урамшуулан дэмждэг.
- Оюутныг тэтгэлэгт байгууллагын тэтгэлэг болон эрдэм шинжилгээний хурлуудад амжилттай оролцоход дэмжлэг үзүүлдэг.
- 2019 онд ШУТИС-ийн ректорын тушаалаар БуХС-ийн НА хөтөлбөрөөс 4 оюутанд авсан байна. Тодруулбал 1 оюутан 3 кредитын урамшуулал авсаныг мөнгөн дүнгээр бодох юм бол 236700 төгрөг нийт 12 кредит цаг 946800 мянган төгрөгний урамшуулал эдэлсэн байна.
- 2017 онд оюутны зөвлөлд өгсөн дэмжлэг нь 13,102 сая төгрөгийг олгосон.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны зөвлөл болон клубуудын үйл ажиллагааг сайн дэмждэг.

**Анхаарах асуудал:**

- Суралцагч оюутнуудыг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулахад төсөв санхүүгийн дэмжлэг сүүлийн 2 жил буурсанд анхаарах.
- Оюутнуудыг сайн дурын ажилд оролцуулах, дэмжих хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж ажиллах

**Зөвлөмж:**

- Бакалаврын түвшинд суралцаж байгаа оюутан суралцах хугацаандаа сайн дурын ажилд хамрагдаж, хувь хүний хөгжлийн чиглэлээр сургуулиас зохион байгуулж хэд хэдэн сургалтад хамрагдаж байж төгсдөг болох бодлогыг сургуулиас дэмжин кредитийн үнэлгээнд оруулах.

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг дотоод дүрэм журмын дагуу зохицуулдаг.
- Сургуулийн санаачлагаар гэрээ цуцалсан, шилжилт хөдөлгөөн хийгдсэн тохиолдол Нийгмийн ажил хөтөлбөрөөр суралцагчдын хувьд гараагүй.
- Оюутныг тэтгэлэгт байгууллагын тэтгэлэг болон эрдэм шинжилгээний хурлуудад амжилттай оролцоход дэмжлэг үзүүлдэг.
- Эрүүл мэндийн төв, сэтгэл зүйн төв болон оюутны байрны хүрэлцээ хангамж, үйлчилгээ сайн байгаа нь шилжилт хөдөлгөөнийг багасгах боломж бүрдүүлдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэн суралцагчид эхний 1 жилдээ мэргэжлээ сонгох боломжтой байдаг буюу чөлөөтэй хөрвөх эрхтэй байдаг.

**Анхаарах асуудал:**

- Суралцагч оюутнуудыг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулахад төсөв санхүүгийн хүндрэл байдаг.
- Сургалтын алба, номын сангийн ажилчдын харилцааны соёлд анхааран ажиллаж, харилцааны соёл, ёс зүйн сургалтанд хамруулах, тэдний ажил үүргийн талаарх сэтгэл ханамжийн судалгааг оюутнаас тогтмол авч, үр дүнг хэлэлцүүлэхэд анхаарч ажиллах.

**Зөвлөмж:**

- Гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж, 2+2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжийг судлах
- Хөтөлбөрийг сурталчлах үйл явцыг өргөжүүлэн салбар, болон сургуулиа сурталчилж, мэргэжлийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх.
- Бакалаврын зэрэгтэй элсэгч болон шилжин ирсэн тоо, кредит дүйцүүлсэн байдал товчоо, кредитээс чөлөөлсөн байдалд дүн шинжилгээ хийж ажиллах

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөгч оюутнуудад зориулсан ажил олгогчдын тусгайлсан сургалт, ажлын байрны танилцуулга, үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Нийгмийн ухааны салбар нь ШУТИС-ийн дүрэм журамд нийцүүлэн Төгсөлтийн ажил бичих шаардлагыг нарийн томьёолон боловсруулсан бөгөөд энэхүү шаардлагын дагуу төгсөгч оюутан дипломын ажил бичдэг.
- Төгсөгч оюутнуудад диплом олгох үйл ажиллагаа тодорхой дэс дараалал, тогтсон дүрмийн дагуу явагддаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Стандартад нийцсэн байдаг нь давуу тал байна.

**Анхаарах асуудал:**

- Төв сургуулиас зайтай оршдог учир ШУТИС дээр явагддаг төгсөгч оюутанд зориулсан хөдөлмөрийн биржийн үйлчилгээ болон бусад үзэсгэлэнд оролцоход хүндрэлтэй.

**Зөвлөмж:**

- Ижил төстэй хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудаас ялгарах онцлог, давуу талыг тодорхойлж хэрэгжүүлэх.

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан.**

## Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**
Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа багш нарт докторын сургалтын төлбөр, докторын зэрэг хамгаалах зардалд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, цалинтай чөлөө олгодог, ном бүтээлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.
- Багшийг үнэлэх 3 чиг үүргээс Б болон В цагийн хүрээнд багш нар өөрсдийгөө хөгжүүлэх ажлаа тайлагнаж, харгалзах үнэлгээ, урамшуулал авдаг. Эдгээр цагийн хүрээнд 7 бүлэг бүхий шалгуурыг ашигладаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Дотоод, гадаадын боловсролын байгууллагуудын сургалтын талаар баримталж байгаа бодлого, тэргүүн туршлагыг өөрийн үйл ажиллагаандаа байнга, тогтмол нэвтрүүлж, багш суралцагчдыг дэмжин урамшуулах, тэдэнтэй хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлсэн.
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувь өндөр

**Анхаарах асуудал:**

- Багшийн хүний нөөцийн талаар бодлого, хөтөлбөртэй болоход анхаарах

**Зөвлөмж:**

- Гадаад, дотоодод докторын зэрэг хамгаалсан багш нарын нөөцөд тулгуурлан Үндэсний хэмжээний судалгааны багийг бүрдүүлэн ажиллах
- Хөтөлбөрийн багш нарын хоорондоо мэдээлэл дамжуулах урсгалыг нэмэгдүүлэх замаар багаар ажиллах чадварыг хөгжүүлэх

**6.2. Багшийн хөгжил**
Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

**Илрэл нотолгоо:**

- CDIO-ийн сурган заах арга зүйн сургалт, оны шилдэг багш нарын цуврал сургалтыг зохион байгуулсан.
- Судалгааны арга зүй, судалгаа боловсруулах программ хангамжийн сургалт, туршлага солилцох сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн хөгжлийн төв байгуулагдсанаас хойш 2 жилийн хугацаанд багш нарыг хөгжүүлэх 5 чиглэлээр 40 гаруй ажил зохион байгуулсан.
- Багш нар дотоодод болон гадаадад сургалт, эрдэм шинжилгээний хуралд оролцож, мэргэжил дээшлүүлсэн байна.

**Анхаарах асуудал:**

- БуХС- ийн 2014-2019 оны санхүүгийн тайлангаас харвал багшийн хөгжилд зарцуулж буй зардал 3 дахин буурсан байна.
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй нэгж, ажлын байран дээр багшийн мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх боломж олгож буй байдал, нэгжээс зохион байгуулах үйл ажиллагааны чигэлэлийг боловсруулж ажиллах

**Зөвлөмж:**

- Багшийн хөгжлийн төвийн төсвийг нэмэх замаар багшийн эрдэм шинжилгээний хуралд оролцох боломжийг нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хөгжилд хөтөлбөрийн орлогоос хувь нэмэгдүүлэн санхүүжилт олгох боломжийг судлах

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**
Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Гадны захиалгаар судалгааны ажил хийж гүйцэтгэдэг.
- Багш нар сүүлийн 5 жилд 25 томоохон төсөл, хөтөлбөрийн судалгааны ажлыг гэрээлэн гүйцэтгэсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар 18 ном, сурах бичиг, гарын авлага хэвлүүлэн 4 бүтээлд зохиогчийн эрхийн патент авсан.
- EBSCO, SPRINGER зэрэг 10 гаран судалгааны сангуудад нэвтрэх эрхийг худалдан авч судлаачид үнэгүй ашиглах боломжоор хангасан.

**Анхаарах асуудал:**

- Гадаад, дотоодын хамтарсан судалгааг өргөжүүлэх
- Эрдэм шинжилгээний хурлыг төр, ТББ, их сургуулиуд, хувийн хэвшил, ОУБ хамтран зохион байгуулах

**Зөвлөмж:**

- Бусад сургууль, нэгжтэй хамтран их семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах боломжыг өргөжүүлэх

- Эрдэм шинжилгээний хурал, илтгэл, хэлэлцүүлгийн зохион байгуулалтын олон хэлбэрийг ашигладаг байх
- Эрдэм шинжилгээний зардал, төсөл хөтөлбөр санхүүжүүлсэн байдал, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд ямар үр нөлөө үзүүлсэн тухай тоон болон чанарын үзүүлэлтүүдийг боловсруулж ажиллахад анхаарах

**6.4. Багшийн үнэлгээ**
Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багш бүр улирал бүр өөрийн үнэлгээний тайлан бичдэг.
- Багшийн үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн хөндлөнгийн үнэлгээг UNIMIS системийг ашиглан цахимаар хийх боломжтой.
- Багш бүр өөрийгөө үнэлэн тайлангаа бичээд, дараа салбар сургуулийн удирдлага, хамт олноор үнэлүүлээд, тодорхой шалгуур давж, болзол хангасан багш нар урамшуулал авдаг.

**Анхаарах асуудал:**

- Гадаадад эрдэм шинжилгээний хуралд оролцогчдын дараагийн үр өгөөж, ач холбогдолд анхаарах

**Зөвлөмж:**

- Шилдэг багш нарын шалгаруулалтыг ил тод, нээлттэй болгох
- Багшийн нийгмийн асуудлыг судлан, дэмжлэг үзүүлэх
- Цагийн тооцоо, багшын ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцдэг, ажлын үр дүнг тооцож ажиллахад нэгж, сургуулийн удирдлага анхаарч ажиллах

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**
Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

- “Нийгмийн ажил” хөтөлбөрт CDIO нэвтрүүлэх, сургалтын төлөвлөгөөний дагуух сурах бичиг, бие даалт, оюутны үнэлгээ, лекцийн агуулга, тестийн санд тулгуурласан суралцагчдад мэдлэг, ур чадвар олгох сургалтын төлөвлөгөө, тестийг UNIMIS программд шилжүүлсэн.
- Хөтөлбөрийн дэд хороо хичээлийн жилээр төлвөлгөө гарган ажилладаг, төлөвлөгөөнд хөтөлбөрт өөрчлөлт оруулах, хөтөлбөрийг үнэлэх, сурган заах арга зүйн сургалт зохион байгуулах, дэд хорооны гишүүдийг чадваржуулах, хөтөлбөрийн хэрэгжилтэнд дотоод хяналт шинжилгээ, чанарын баталгаажуулалт хийх зэрэг ажлыг тусган хэрэгжүүлдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2018-2019 оны хичээлийн жилд 11 профессор, багш нарын 40 орчим цагийн лекц, семинарийн нээлттэй хичээлд сууж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
- Хөтөлбөрийн дэд хороогоор Нийгмийн ажил хөтөлбөрийн өөрчлөлтийн санал 2 удаа оруулж хэлэлцүүлэн ерөнхий хороонд хүргүүлэн амжилттай шийдвэрлүүлсэн.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хүрээнд заагдаж буй хэлний хичээлүүдээр оюутан гадаад хэлийг бүрэн эзэмших боломж бага байдаг нь ажил олгогчийн шаардлагыг хангадаггүй.
- Хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөртөө хэрхэн тусгаж байгаа талаар оролцогч талд байнга мэдээлэх
- Хичээлийн үнэлгээний шалгуурыг боловсруулж, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлтэнд хэрэгжүүлж хэвшүүлэх

**Зөвлөмж:**

- Суралцагч, ажил олгогч, сургууль, эцэг эхийн хөндлөнгийн хамтын үнэлгээг нэвтрүүлэх

**7.2. Хөтөлбөрийн үр дүн**
Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Нийгмийн ажил хөтөлбөрөөр 2015-2019 оны нийт 105 төгсөгчдийн судалгаагаар 76 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна.
- Нийгмийн ажил хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын 2018 оны судалгаагаар 50-59 хувь нь энэ мэргэжлээр суралцаж байгаадаа сэтгэл ханамжтай, хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлт оюутны хөгжил, мэдлэг, чадвар, дадалд эерэг нөлөө үзүүлдэг гэсэн байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд 45 эцэг эхээс авсан сэтгэл ханамжийн судалгаанд 67 хувь нь сэтгэл хангалуун байна гэдгээ илэрхийлжээ.

- Ажил олгогчдын судалгаагаар төгсөгчдийн мэдлэг, чадваруудаас идэвхи санаачилга, зан харилцаа, ёс зүй сайтай гэдгийг онцолсон байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Оролцогч талуудын эрэлт, шаардлагыг тодорхойлохын тулд төгсөгчидтэй уулзалт хийх, хамтран ажиллагч байгууллагуудтай ярилцлага, сургалт, эрдэм шинжилгээний хурал хийх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан саналыг нь авч хөтөлбөрийн өөрчлөлтөндөө тусгадаг
- Нийгмийн ажилтан мэргэжилтэн бэлтгэсэн туршлагын хувьд Монголд Нийгмийн ажилтан бэлтгэж эхэлсэн анхны хөтөлбөрүүдийн нэг бөгөөд 23 жилийн түүхэн туршлагатай.

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг байнга хийх
- Хөтөлбөрийн үр дүнг олон нийтэд мэдээлэх, бусад сургуулиудтай туршлагаа хуваалцах, өрсөлдөх бус хамтарч ажиллах стратегийг сонгох
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн төгсөгчийн болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны  болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжлийг хангаж чадах эсэх, түүнийг гарааны ахицын, нэгдсэн үнэлгээгээр хэмжих зохицуулалт хийхэд анхаарч ажиллах

**Зөвлөмж:**

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэхийн тулд төгсөгчдийн мэдлэг, ур чадварын талаарх судалгааны үр дүнг хөтөлбөрт байнга тусгаж байх
- Эцэг эхийн судалгааг жил бүр тогмол хийж байх,
- Суралцагч анх хөтөлбөрөөр элсэхдээ ямар байсан төгсөхдөө ямар түвшинд хүрсэн гэдгийг харьцуулсан судалгаа хийх

**7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**
Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Гадаад, дотоодын мэргэжлийн 7 байгууллагатай хамтарч ажилладаг.
- Хөтөлбөрөөр төгсөгчид тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- KOICA ОУБ-тай хамтран ажиллаж, сайн дурын зөвлөх Зочин профессорыг ажиллуулж байна.
- БНСУ-ын Гуанжу хотын нийгмийн холбоотой хамтран 6 багш туршлага судалсан.

- Нийгмийн ажлын багш сургагчдын холбоо, Нийгмийн халамжийн байгууллагуудын нэгдсэн холбоо, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэгтэй хамтран ажилладаг.

**Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн ТББ-тай гэрээний үндсэн дээр төлөвлөгөөтэй хамтран ажиллах
- Бусад байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох бус өөрсдөө санаачилан зохион байгуулахад түлхүү анхаарах
- Хөтөлбөрийн үзэл баримтлалын талаар, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын талаарх мэргэжлийн багш, сургуулийн үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллах

**Зөвлөмж:**

- Судалгаа, шинжилгээний төв байгуулах, баг бүрдүүлэх нөөц боломжийг судлан, эрдэм судлалын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын түвшинд хүргэхэд анхаарах

## ДҮГНЭЛТ

| Шалгуур | | Бүрэн хангасан (2) | Хэсэгчлэн хангасан (1) | Хангааг үй (0) | Үндэслэл, шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөтөлбөрийн төлөвлөлт | 2 | 1 | - | 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд |
| 2 | Сургалтын үйл ажиллагаа | 2 | 1 | - | 2.2 Сургалтын арга зүй |
| 3 | Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, техологийн нөхцөл | 3 | - | - | |
| 4 | Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт | 3 | 2 | - | 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа<br>4.3 Санхүүжилт |
| 5 | Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа | 2 | - | - | |
| 6 | Багшийн үйл ажиллагаа | 2 | - | - | |
| 7 | Чанарын үнэлгээ, баталгаажуулалт | 2 | - | - | |
| **Дүгнэлт** | | **Бүрэн хангасан** | | | |

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ШУТИС-ийн Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуурт нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .......................................... /Т.Цэндсүрэн/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг .......................................... / Б.Сүх-Очир/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг .......................................... / Г.Мөнхнасан/

## ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

- Хичээлийн хөтөлбөрийг баталгаажуулахдаа сургалтын хөтөлбөрийн үр дүнд чиглүүлж, агуулга, эзэмших чадварын хувьд харилцан залгамж холбоог хангаж, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт хэлбэрийг тусгаж ажиллахад анхаарах.
- Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт Төгсөгчийн эзэмших ур чадвар, Суралцагийн үнэлгээ, Удирдлага мэдээллийн сантай холбоотой бүлгүүд орхигдсон байгааг анхаарч хөтөлбөрт нэмж тусгах, сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн харьцаанд (БСШУЯ-ны сайдын А/174 тушаал үзэх) хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж анхаарах.
- Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөлд (БСШУСЯ, 2020 оны 3 сарын 2) Нийгмийн ажил хөтөлбөр 120 багц цаг сургалт явуулах зөвшөөрөлтэй байгаа боловч одоо мөрдөж байгаа (2016 онд батлагдсан) сургалтын төлөвлөгөө нь 122 багц цагийн агуулгатай буюу тусгай зөвшөөрлийг зөрчсөн дутагдал ажиглагдаж байгааг анхаарч засах шаардлагатай.
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн үр дүнтэй нийцэж байгаад сургалтанд оролцогч, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд үндэслэн дүн шинжилгээ хийх ажлуудыг эхлүүлсэн байгаа ч хөтөлбөрт дотоод болон гадаад чанарын батгаажуулалт хийх үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай.
- Оюутны клубын болон  сайн дурын ажлыг зөвлөх дэмжих үйлчилгээг хөгжүүлэх, үйл ажиллагааг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөтэй зохион байгуулж ажиллах, үр нөлөөг судлан дүн шинжилгээ хийдэг байх.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хөгжилд хөтөлбөрийн орлогоос орох санхүүжилтыг нэмэгдүүлэх, багшийн хөгжлийн төвийн төсвийг нэмэх замаар эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэхэд анхаарах.

## IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

### I. Багш нарын нэрс

| | Багийн гишүүдийн нэр | Албан тушаал | Ажиллаж асан жил | Заадаг хичээл | Цахим хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Я.Төгөлдөр | Салбарын эрхлэгч | 22 | Улс төр судлал | tugul@must.edu.mn 91910393 |
| 2 | Б.Бат-Өлзий | Дэд профессор | 17 | Нийгмийн судалгааны арга зүй | bbatulzii04@gmail.com 99052526 |
| 3 | Т.Амаржаргал | Ахмад гэрээт | 40 | Нийгмийн ажлын онол<br>Нийгмийн ажлын ёс зүй | amarjargal57@yahoo.com 99188248 |
| 4 | Б.Даваажав | Ахмад гэрээт | 40 | Хүний хөгжил | 99197957 |
| 5 | С.Туяа | Ахлах багш | 22 | Нийгмийн бодлогын анализ<br>Нийгмийн ажлын менежмент | s.tuya@must.edu.mn 91112464 |
| 6 | Н.Ариунтуяа | Ахлах багш | 20 | Сэтгэл судлал<br>Сэтгэл зүйн зөвлөгөө засал | ariuntuya.n@must.edu.mn 99078399 |
| 7 | Н.Нямдорж | Ахлах багш | 17 | Нийгмийн ажлын микро практик<br>Нийгмийн ажлын макро практик | nyamaa89@gmail.com 99855519 |
| 8 | Б.Болормаа | Ахлах багш | 9 | Хүүхэд хамгаалал<br>Гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил | bumbaalai8888mn@yahoo.com 94092529 |
| 9 | А.Нарангэрэл | Ахлах багш | 11 | Нийгмийн хамгааллын эрх зүй<br>Нийгмийн эрүүл мэнд | naraatushi@yahoo.com 93140657 |
| 10 | Т.Оюунбилэг | Ахлах багш | 20 | Нийгмийн технологи<br>Ерөнхий социологи | tbtr.oni@gmail.com 99177048 |
| 11 | С.Ариунцэцэг | Ахлах багш | 19 | Нийгмийн ажлын түүх<br>Дадлага хариуцах | sbt_aru@yahoo.com 99096659 |
| 12 | Т.Должинсүрэн | Ахлах багш | 8 | Насан боловсролын арга зүй | doljinsuren012@gmail.com 88027108 |
| 13 | Д.Юмжирмаа | Багш | 10 | Сэтгэл судлал | yumjirmaa@must.edu.mn |
| 14 | Б.Ундрал | Сургалтын мастер | 1 | | sharaid@gmail.com 88007790 |

**II. Оюутны нэрс**

| № | Оюутны нэрс | Курс | Сонгосон байдал | Утас | Цахим хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | М.Найдан-Очир | Нийгмийн ажил-IV | Хөдөө орон нутгаас суралцагч | 91373812 | naidka4eva@yahoo.com |
| 2 | М.Дөлгөөн | Нийгмийн ажил-IV | Голч дүн өндөр | 88224132 | duku_1221@yahoo.com |
| 3 | У.Нарантуяа | Нийгмийн ажил-IV | Дотуур байр | 88149027 | Narantuya04270715@gmail.com |
| 4 | Э.Мөнхбаяр | Нийгмийн ажил-IV | Хөгжлийн бэрхшээлтэй 75 % | 95058568 | munkhbayar1116@gmail.com |
| 5 | Г.Золжаргал | Нийгмийн ажил-III | Дотуур байр | 95661711 | gzoljargal2000@gmail.com |
| 6 | Д.Энхзаяа | Нийгмийн ажил-III | Голч үнэлгээ | 86870616 | enkhzaya616@gmail.com |
| 7 | Ч.Гончигсумлаа | Нийгмийн ажил-III | Хөдөө орон нутгаас | 99986997 | gonchigsumlaa990@gmail.com |
| 8 | Б.Минжинсор | Нийгмийн ажил-III | Нийгмийн идэвхи оролцоо сайн дурын ажил | 80930123 | bmsorasora166@gmail.com |
| 9 | Б.Өнөрзул | Нийгмийн ажил-III | Нийгмийн идэвхи оролцоо сайн дурын ажил | 88876544 | Unurzul Battulga<br>Unurzulbattulga21@gmail.com |
| 10 | Д.Пүрэвбат | Нийгмийн ажил-III | Хөдөө орон нутгаас суралцагч | 99640029 | Purevbat_0608@yahoo.com<br>Д. Пүрэвбат |
| 11 | Х.Мөнхжин | Нийгмийн ажил-II | Нийгмийн идэвхи оролцоо сайн дурын ажил | 85832112 | kh.munkhjin2112@gmail.com |
| 12 | А.Нандинцэцэг | Нийгмийн ажил-II | Хөдөө орон нутгаас | 94393299 | nandikaashdee800@gmai.com |
| 13 | Э.Сансармаа | Нийгмийн ажил-II | Нийгмийн идэвхи оролцоо сайн дурын ажил | 86127058 | esansarmaan37@gmail.com |
| 14 | Н.Өлзийбаяр | Нийгмийн ажил-II | Голч дүн өндөр | 86669602 | ulziiko.nym@gmail.com |
| 15 | Б.Саруултөгс | Нийгмийн ажил-II | Нийгмийн идэвхи оролцоо сайн дурын ажил | 88334582 | boldbaatarsaruultogs@gmail.com |
| 16 | Х.Болормаа | Нийгмийн ажил-II | Дотуур байр | 96644299 | bboloroo42@gmail.com |
| 17 | Д.Нямдолгор | Нийгмийн ажил-I | Голч дүн өндөр | 99463709 | nymdolgorderem@gmail.com |
| 18 | Э.Сосорбурам | Нийгмийн ажил-I | Хөдөө орон нутгаас суралцагч | 95287728 | enkhochirsoko11@gmail.com |
| 19 | Л.Мөнхцэцэг | Нийгмийн ажил-I | Дотуур байр | 85706052 | lmunkhtsetseg613@gmail.com |

## II.Ажил олгогчдын нэрс

| № | Овог нэрс | Байгууллага, албан тушаал | Утас | E-MAIL |
|---|---|---|---|---|
| 1 | Ч.Очгэрэл | ШШГЕГ Захиргаа мониторингийн газрын дарга | 98887000 | ochsan7000@gmail.com |
| 2 | А.Чимэгсүрэн | ХХҮЕГ | 99004062 | achimegsuren@yahoo.com |
| 3 | н.Арвинтариа | Хүчирхийллийн эсрэг үндэсний төв | 99007360 | arvin_taria@yahoo.com |
| 4 | Э.Цолмон | Хүүхдийн ивээх сан (Япон) | 99007360 | tsolmon.enkhbat@savethechildren.org |
| 5 | М.Отгонтуяа | СБД-ийн ХХҮГ хэлтсийн дарга | 88116853 | otgontuya_mgl@yahoo.com |
| 6 | Н.Мандуул | НГБХЗХГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | 88092176 | natsag.manduul@gmail.com |
| 7 | С.Отгонсүрэн захирал | Хүүхдийн тусламжийн утас 108 утас, хамгаалах байрны захирал | 88028782 | huuhdiinutas108@gmail.com |
| 8 | н.Алтанцэцэг дарга | Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор | 98114844 | altantsetseg@happykids.edu.mn |

## IV. Төгсөгчдийн нэрс

| № | Оюутны нэрс | Төгс сөн он | Байгууллага, албан тушаал | Утас | Цахим хаяг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Б.Энхсаруул | 2015 | БНСУ-д Туншин Их сургуульд Нийгмийн ажлын магистр сурч мэргэжлээрээ ажиллаж байна. | 01080629109 | B.enhsaruul0828@gmail.com |
| 2 | Д. Анхцэцэг | 2015 | Шинэ-Үе мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн нийгмийн ажилтан | 88720054 | Anhaa_chief@yahoo.com |
| 3 | Б. Мөнхнасан | 2016 | ШШГЕГ-429 хорих ангид нийгмийн ажилтан | 91851818 | Munkhnasan MN |
| 4 | Б.Мөнх-Эрдэнэ | 2016 | Дэлхийн зөн ОУБ СХД салбарт мэргэжилтэн | 89004992 | munkerdene.bya@gmail.com |
| 5 | Р.Нарантунгалаг | 2017 | ХУД 118-р сургуулийн нийгмийн ажилтан | 90101045 | narantungalagr@gmail.com |
| 6 | Г.Баасансүрэн | 2017 | Хөвсгөл аймгийн гэр бүл хүүхэд залуучууд хөгжлийн газрын залуучууд хөгжлийн төвийн хөгжил соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн | 98868601 | Baasansuren.baska@ yahoo.com |
| 7 | | | ШШГЕГ харъяа сургалт | 94110768 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Ц.Дэжид | 2018 | хүмүүжлийн тусгай байгууллага Нийгмийн ажилтан дэслэгч цолтой | | tsagaandejid@yahoo.com |
| 8 | Б.Индра | 2018 | Дундговь аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Сайхан-Овоо сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн | 89646490 | bayasgalan.indra@yahoo.com |
| 9 | Н. Бат-Аврал | 2019 | Нийслэлийн Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт Залуучуудын төвийн нийгмийн ажилтан | 95170333 | Bat-Avral@happykids.ede.mn |
| 10 | Э.Чулуунчимэг | 2019 | Нийслэлийн 129-р сургуульд сургуулийн нийгмийн ажилтан | 95189971 | Chuuka947@gmail.com |

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
**БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ**
13361 ш/х-49/313, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
2 дугаар хороо, Их тойруу, ШУТИС-ийн V байр,
Утас/Факс: (976-11) 45 81 51, И-мэйл: secretary.sbh@must.edu.mn,
Вэбсайт: www.sbh.edu.mn

2020.06.11 № 332
танай ____________-ны №____________-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНД

Санал хүргүүлэх тухай

Тус сургуулийн “Нийгмийн ажил” хөтөлбөрийн 2 дахь удаагийн магадлан итгэмжлэлд ажилласан Шинжээчдийн багийн санал зөвлөмжтэй танилцлаа. Санал, зөвлөмжийг цаашдын ажилд тусган ажиллах болно.

Хамтран ажилласанд баярлалаа.

ЗАХИРАЛ А.ЭНХБАТ

367760222